



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2015 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 92

Улаанбаатар хот

“Кредит монгол ББСБ” ХХК-ийн  
банк бус санхүүгийн гадаад валютын арилжаа эрхлэх  
тусгай зөвшөөрлийг сэргээх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 186 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 10.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Кредит монгол ББСБ” ХХК-ийн банк бус санхүүгийн гадаад валютын арилжаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сэргээсүгэй.
2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Кредит монгол ББСБ” ХХК /У.Барсболд/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Энхбаяр/-нд даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

000614